

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код

Автотээврийн хэрэгслийн резин дугуй засварын үйлчилгээ. Тавигдах шаардлага.	MNS:
	MNS:

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн .... оны...сарын .....өдрийн .... дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь ....оны.....сарын ... өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын үзүүлэлт шаардлагыг заавал мөрдөнө.

### 1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь автотээврийн хэрэгслийн резин дугуй тайлах, задлах, нөхөх, хийлэх, шалгах, угсрах, тэнцвэржүүлэх, солих ~~/цаашид дугуй засварын газар/~~ гэх ажил үйлчилгээ эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино.

### 2. Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандартыг резин дугуй засварын үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон түүнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө. Энэхүү стандарт нь хүнд даацын тээврийн хэрэгслийн резин дугуй засвар үйлчилгээнд хамаарахгүй.

### 3. Норматив ишлэл

Энэхүү стандартыг боловсруулахад ашигласан дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ. Үүнд:

-MNS 5025 Авто үйлчилгээ – Ангилал, Ерөнхий шаардлага.

-MNS 4601 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн, техникийн үйлчилгээ, засварын тогтолцоо, тодорхойлолт.

-MNS 4598 Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага.

#### **4. Нэр томъёо, тодорхойлолт**

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томъёог доор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:

**4.1 Дугуй засвар**- Автотээврийн хэрэгслийн резин дугуйг зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглан тайлах, задлах, нөхөх, хийлэх, шалгах, угсрах, тэнцвэржүүлэх, солих, хадгалах, дуудлагаар үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

**4.1 Дугуй засвар эрхлэгч** – Автотээврийн хэрэгслийн резин дугуй засварын үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах нөхцөл шаардлагыг хангасан барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажиллах боловсон хүчин зэргээр хангагдсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг;

**4.2 Дугуй засварын технологи** – Дугуйг тайлах, задлах, нөхөх, хийлэх, шалгах, угсрах, тэнцвэржүүлэх, солих, хадгалах, дуудлагаар үйлчилгээ үзүүлэх ажилбаруудыг шаардлага хангасан барилга байгууламжинд зориулалтын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар тодорхой цаг хугацаанд зохих нөхцөл шаардлагын дагуу мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх ажлын дарааллыг;

**4.3 Технологийн карт** – Дугуй засварын ажилбаруудын дэс дараалал, ажиллах боловсон хүчин, засварын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, зохих нөхцөл шаардлага, ажил гүйцэтгэх хугацаа зэргийг тусгасан техникийн баримт бичгийг;

**4.4 Дугуй засварчин** – Авто машины дугуй засварлах технологи ажиллагааг шаардлагын дагуу хийж гүйцэтгэх мэргэшсэн ажилчныг;

**4.5 Дугуй засварын байр**- Автомашины дугуй засварын үйлчилгээ хийх нөхцөл шаардлага хангасан технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий ажиллах орчинг;

**4.6 Автотээврийн хэрэгслийн резин дугуй засвар, дугуйн баланс тохируулах үйлчилгээ**  
Автотээврийн хэрэгслийн резин дугуйг зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглан тайлах, задлах, нөхөх, хийлэх, шалгах, угсрах, тэнцвэржүүлэх, солих, хадгалах, дугуйнд хээ тавих, дуудлагаар үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа хамаарна.

**Нэг бол автомашин нэг бол автотээврийн хэрэгсэл аль нэгээр нь цааши явах хэрэгтэй.**

**4.7 дугуйн ам тэгшлэгч**

**5 Технологи ажиллагаа /энэ хэсэг заавал стандартчлагдах шаардлагагүй байх /**

5.1 Тэгш гадаргуутай талбайд автотээврийн хэрэгслээ зогсоогоод ажиллахад хангалттай зай талбай гаргана. Хөдөлгүүрээ унтраана. Автомат хурдны хайрцагтай бол “Р” байрлалд, механик хурдны хайрцагтай бол ухрах араанд хийнэ. Мөн зогсоолын тоормосоо ажиллуулж автотээврийн хэрэгслээсээ хүмүүсийг буулгана.

5.2 Нөөц дугуйн хийг шалгана. Хэрэв хэвийн байвал, дугуй, домкрат, бусад багаж хэрэгслээ тээшний хөндийгөөс буулгана.

5.3 Отворкаар дугуйн булны тагийг хөшиж авна.

5.4 Дорцоовоор булны гайкнуудыг суллаж авна. Хэрэв гайкнууд хэт чанга бол нэвтрэмтгий төс түрхэж, эргүүлнэ. Ихэнх гайк “зөв” резьбатай байх тул цагийн зүүний эсрэг эргүүлж суллана. Зарим гайк “буруу” резьбатай тул тэднийг цагийн зүүний дагуу эргүүлж суллана. Гайк “L” гэсэн тэмдэгтэй бол “буруу” резьбатай гэсэн үг. Зарим автомашин “зөв” болон “буруу” резьбатай гайктай байх нь бий. Тэдний хувьд гайкийг автотээврийн хэрэгслийн хойд тал руу эргүүлж суллана.

5.5 Домкратыг зааврийн дагуу угсарна.

5.6 Солих дугуйн диагналын дагуу эсрэг байралсан дугуйнд ивээс хийнэ. Дараа нь домкратаа зөв байрлуулна. Тулах газар нь зөөлөн бол банз юмуу зузаан фанер доор нь байрлуулж доош шигдэхээргүй болгоно.

5.7 Газраас дугуй дөнгөж хөндийрөхөөр өргөнө. Домкратны бариулыг авна.

5.8 Булны гайкнуудыг дорцоовоор суллаж, булны хаалтан дотор / хаягдахааргүйгээр/ тавина. Дугуйгаа суллаж авна.

5.9 Нөөц дугуйгаа тавих газар нь өнхрүүлж төхүүлнэ. Домкратаар автотээврийн хэрэгслийг дахин бага зэрэг өргөж, нөөц дугуйгаа буланд оруулж байрлуулна. Домкратны бариулыг авна. Дугуйн нүхийг боолтнуудад амсуулан тааруулна.

5.10 Дугуйгаа нэг гараараа сайтар түшиж байгаад нөгөө гараараа гайкнуудыг эрэгүүлнэ.

5.11 Дорцоовоор сөөлжилж гайкнуудыг чангална.

5.12 Автотээврийн хэрэгслээ доош буулган домкрат болон ивээсийг авна. Гайкнуудыг зөв дарааллаар дахин чангална. Дугуйн хаалтыг тавьж, резин алхаар зөөлөн тогшиж суллга. Бүх багаж хэрэгслээ буцаан хурааж, байранд нь тавина. Хагарсан дугуйгаа байранд нь байрлуулна.

## 6 Дугуй засвар эрхлэгчдэд тавих ерөнхий шаардлага

6.1 Нутаг дэвсгэрийнхээ бүртгэх байгууллагад тогтоосон журмын дагуу бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан, эрхлэх ажил, үйлчилгээний нэр төрөл, үйл ажиллагааг тодорхой заасан байх. **????? / арай чанга шаардлага байна. Үүний оронд тухайн орон нутгийн засаг захиргааны нэгжтэй Ажил үйлчилгээ явуулах гэрээ байгуулсан байна гэх мэт байвал яаж байна. ???/**

6.1 Дугуй засвар эрхлэгч нь үйлчилгээний зориулалтын барилга байгууламж, зогсоол талбай, технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байна.

6.2 Дугуй засварлах ажил үйлчилгээ нь 3-аас доошгүй автомашины зогсоолтой байх бөгөөд ~~хүрээлэн байгаа байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх,~~ замын хөдөлгөөнд саад учруулж, автозамын зорчих хэсгийг зогсоолын зориулалтаар ашиглахгүй байх.

6.3 ~~Галын болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, хөдөлмөрийн эрүүл ахуйн болон тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлж,~~ Дугуй засвар эрхлэгч нь гүйцэтгэсэн ажил үйлчилгээндээ техникийн үзүүлэлт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаад баталгаа гаргаж өгнө.

6.4 Ажил үйлчилгээтэй холбогдсон дугуй засварын технологийн карт, техникийн болон эрүүл ахуйн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын заавар журмыг батлаж мөрдөнө. **дугуй хийн даралтыг тээврийн хэрэгслийн хаалга дээр үйлдвэрлэгчээс тэмдэглсэн байдлыг оруулж өгөх хэрэгтэй.**

6.5 Дугуй засварын технологийн карттай байна.

6.6 Ажлын байр нь тулгуур, ивүүр, домкрат, задлагч, угсрагч, компрессор /хий хураагуур/, торцов, торцов нь /резво тоологчтой гараар суллаж, чангалах/ зориулалтын устай тэвш, хийн домкрат, базак /дугуйн ам тэгшлэгч/, Найдвартай, хангалттай нарийвчлалтай манометртай хэмжигч гартай байна. манометр нь поршент, цагираг болон тоон хуваарьтай гэсэн олон янз байна. **/ ЭНЭ ХЭСГИЙГ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИХ ШААРДЛАГА ГЭЭД ЗАДЛАЖ БИЧИХ НЬ ЗҮЙТЭЙ. БЛАНС ТОХИРУУЛАГЧ, ДУГУЙ ЗАДЛАХ ЗОРИУЛАЛТЫН ШИНГЭН ГЭХ МЭТ НЭМЭХ/**

6.7 Автотээврийн хэрэгслийн резин дугуйг хийлэх үед тусгай зориулалтын өрөө, тасалгаанд хийлдэг байна. **?????**

6.8 **Боолт болон эргийг** үйлдвэрлэгчээс зөвлөсөн хэмжээний хүчээр чангалах ёстой. **Хэрэв танд** динаметртэй торцов байхгүй бол ойр байгаа авто үйлчилгээний газарт хандаж болно.

6.9 Компрессор /хий хураагуур/ нь дуу чимээ тусгаарлагчтай, хангалттай ажиллах агаар бүхий агааржуулагчтай тусгай өрөөнд байрласан байна.

6.10 Базак буюу /дугуйн ам тэгшлэгч/-тэй байна.

6.11 Резин дугуйн хий хэмжигч суурин багажтай байна. Энэ нь хэмжигч гарны заалтыг хянах /хэмжигч гар нь унах, доргих зэргээс хамаараад хийн хэмжээг буруу заах/ тохиолдол байдаг.

6.12 Автотээврийн хэрэгслийн резин дугуйг засварлахдаа зориулалтын хувцас, тусгай гуталтай байна.

6.13 Автотээврийн хэрэгслийн резин дугуй засварын газарт дугуйн гайхыг суллаж, чангалахад гараар чангалагч багаж ашиглана. Дугуйг хийн компрессороор суллаж чангалахад боолтны резво гэмтэх эрсдэлтэй.

## **7 Дугуй засварын барилга байгууламжид тавигдах шаардлага**

7.1 Дугуй засварын барилга, байгууламж нь агааржуулах, гэрэлтүүлэх, дулаацуулах систем, дуу тусгаарлах, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.

7.2 Ажилчдын хувцас солих болон амрах байр, бие засах газартай байна.

## **8 Дугуй засвар эрхлэгчийн ажиллах боловсон хүчинд тавих шаардлага**

8.1 Дугуй засвар эрхлэгч байгууллагын дарга, менежерийн аль нэг нь мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж үнэмлэх гэрчилгээ авсан байна.

8.2 Дугуй засварчин нь засварын байрны технологийн тоног төхөөрөмж, багажийг бүрэн эзэмшсэн, дугуй засварын технологи ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн холбогдох дүрэм, журам, зааврыг судалж, тэдгээрийг мөрдөж ажиллах чадвартай, мэргэжлийн сургалтанд хамрагдсан хүн байна.

8.3 Ажлын байранд хөдөлмөр хамгаалал, аюулгүйн техникийн шаардлага хангасан ажлын хувцсыг өмсөж хэрэглэнэ.

8.4 Автотээврийн хэрэгслийн резин дугуй засварчин нь дугуй засварын чиглэлээр мэргэжлийн сургалтад суралцсан, тээврийн хэрэгслийн резин дугуйны марк, загвар, зориулалтын талаар тодорхой мэдлэгтэй түүнд засвар үйлчилгээ хийх зориулалтын тоног төхөөрөмжийг ажиллуулж, ашиглаж чаддаг, дугуй засвар хийж, хийлсний дараа тусгай тоног төхөөрөмж ашиглан тэнцвэржүүлэлт хийж чаддаг мэргэжлийн үнэмлэхтэй байна.

ТӨГСӨВ.

